

## **ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Хуурамч шатахууны тухай ойлголт нь 2015 оны арваннэгдүгээр сард онцгой албан татварын хувь хэмжээг 400 мянган төгрөг, дизель түлшийг 520 мянган төгрөг болгон тогтоосон үеэс эхтэй юм. Түүнээс хойш завсрын бүтээгдэхүүний эрэлт нэмэгдсэн байдаг. Урьд нь 20, 30 мянган тонн орж ирдэг байсан бол 2016 онд 100 мянган тонн, 2017 онд 150 мянган тонн орж ирсэн мэдээ байна. Завсрын бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд ямар нэг онцгой албан татвар, тусгай зөвшөөрөл шаардахгүй. Тэгэхээр хууль эрх зүйн талаас зөрчилгүй мэт харагдаж байгаа юм.

Нефть үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагаа явуулдаг манай зарим компаниуд хуурамч шатахуун үйлдвэрлэж, иргэдийг хохироосоор байна. Албаныхан төдийгүй хууль хяналтынхан үүнийг мэдэж байгаа боловч тодорхой шийдвэртэй алхам хийхгүй байна. Тэдгээр компаниудын хууль бус үйл ажиллагаа сүүлийн хэдэн жил үргэлжлэн иргэдийг хуурамч шатахуунаар хохироож иржээ. Тухайлбал, керосиныг гэрэлтүүлэгт ашигладаг. XIX зуунд тракторын хөдөлгүүрт ашиглаж байсан нафтаг өдгөө зөвхөн нисдэг тэрэг, онгоцны сэнс цэвэрлэхэд л хэрэглэж байна. Гэтэл олон улсад хэрэглээ нь хэдийнээ хумигдсан бүтээгдэхүүний импорт манайд өссөөр байна. Энэ төрлийн түүхий эдийн хольцтой хуурамч шатахуун нь авто машины эд ангиас эхлээд агаарын бохирдолд хүртэл сөргөөр нөлөөлдөг. Цаашлаад шударгаар татвар төлж буй бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд ч халтай.

Шатахуун импортлогчид хуурамч шатахуун нийлүүлснээс тээврийн хэрэгсэл, техник хэрэгсэл эвдэрч, иргэд, аж ахуйн нэгжүүд жилд 50-60 тэрбум төгрөгөөр хохирч байгаа статистик үзүүлэлт байна. Энэ асуудлыг Засгийн газрын хэмжээнд судалж, шалгах ажлын хэсэг байгуулсан ч өнөөдрийг хүртэл дүгнэлт гараагүй, тодорхой шийдэлгүй, байгаагаас хуурамч шатахуун зах зээлд борлогдсоор байна.

“Монгол Улсын газрын тосны жилийн хэрэглээ 1.86 сая тонн. Үүний 70 хувийг дизелийн түлш эзэлдэг. Харин газрын тосны нэмэлт бүтээгдэхүүн жилд 200-250 мянган тонн орж ирж байна. Энэ нь нийт газрын тосны хэрэглээний 15-18 хувийг эзэлж байгаа юм. Ингээд тооцвол таван машин тутмын нэг нь газрын нэмэлт бүтээгдэхүүнээр явж, эвдэрч байна. Манайд шатахуун импортлох тусгай зөвшөөрөлтэй 15 компани бий. Эдгээр компаниуд ч газрын тосны нэмэлт бүтээгдэхүүнийг оруулж ирж байгаа гэх мэдээлэл байна. Зөвхөн ганц компани л өдөрт 280 вагон керосин, хийн конденсатын нэрмэл дистиллят, хөнгөн фракцын бензин буюу нафта хэмээх бодисуудыг хольж найруулан чанаргүй хуурамч шатахуун болгоод, зах зээлийн үнээс хямдаар түгээх станцуудад нийлүүлдэг аж. Үүн дотор Монгол улсад нэр хүндтэй компаниуд худалдан авч, хуурамч чанаргүй шатахууныг түгээх станцаар дамжуулан зарж борлуулж байгаа юм.

Мөн ийм үйл ажиллагаа явуулж буй компаниуд дээрх бодисуудыг ашигласныхаа төлөө улсад нэг ч төгрөгийн татвар төлөхгүй байна. Тухайлбал, зөвхөн 2017, 2018 оны байдлаар дээр дурдсан, хуурамч шатахуун үйлдвэрлэлийн гол түүхий эд болох 202 мянган тонн бодисыг Монгол Улсын хилээр оруулж ирсэн мэдээ байна.

Ийнхүү хуурамч шатахууныг чөлөөтэй борлуулснаар дараах хэд хэдэн ноцтой сөрөг үр дагаврууд гарч байна. Үүнд:

**ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ:**

Хольцтой шатахуун хэрэглэснээр приус машины карбюратор, поршин амархан муудаж, энэ загварын машин хоёр жилийн дотор хэрэглээнээс гарна. Мөн Портер машины аппарат маш хурдан эвдэрнэ гэсэн тооцоолол байна.

#### УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ:

Газрын тосны дайвар бүтээгдэхүүнийг ямар ч татваргүй оруулж ирээд, онцгой татвартай бүтээгдэхүүнтэй хольж татвараас зугтах боломж гарч байна.

#### АЮУЛГҮЙ БАЙДАЛ:

Шатахуун, керосин холих замаар ийм төрлийн шатахуун гаргаж авдаг. Авиакеросинийг нисэхийн салбарт хэрэглэж байгаа нь нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэхийг мэргэжлийн байгууллагуудаар тодруулах шаардлагатай юм.

#### ЭКОЛОГИ:

Нийтийн тээврийн гол унаа болох автобусны аппарат нь хурдан муудаж, маш их хар утаа хаядаг. Нийслэлд 900 орчим нийтийн тээврийн хэрэгсэл үйлчилгээнд явдаг бөгөөд Монголд оруулж ирэхээс өмнө хэдий хугацаанд үйлчилгээнд явсныг тооцох аргагүй юм. Автомашинаас 2000 орчим төрлийн хорт бодис ялгардаг. Тэдгээрээс нүдэнд үзэгдэж, хэмжигдсэн хэдхэн төрлийн бодис байна. Тухайлбал, азотын дутуу болон давхар исэл, хүхрийн дутуу исэл, угаарын хий, нүүрс хүчлийн дутуу исэл гэх мэт бодисыг нэрлэж болно. Эдгээр бодис амьсгалын замын өвчлөлийг шууд хэлбэрээр үүсгэдэг. Ялангуяа жирэмсэн эх, бага насны хүүхдүүд намхан учраас автомашинаас ялгарах утаа шууд ам руу нь орж, амьсгалын эд эрхтнийг гэмтээж байна.

#### БИЗНЕСИЙН ӨРСӨЛДӨӨНД МУУГААР НӨЛӨӨЛДӨГ

Аж ахуй нэгжүүд шударгаар өрсөлдөх үйл явцад нөлөөлж байна. Иймд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар татварын бааз сууриа тэлж, улсын төсвийн орлогыг өсгөөд зогсохгүй аж ахуй нэгжүүд шударга өрсөлдөх боломж нээгдэнэ.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ